

## **“ОРХОНЫ ХӨНДИЙД ХОТ БАЙГУУЛАХ ТУХАЙ” АСУУДЛЫГ НИЙТЭД ТАНИЛЦУУЛСАН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022.06.17.

№...

Хархорин сум

Хурал өдрийн 11:00 цагт Өвөрхангай аймгийн Хархорин сумын ЗДТГ-т болов.

### **Хуралд:**

УИХ-ын гишүүн, УИХ дахь МАН-ын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн,  
БХБЯ-ны ХБГХБХЗГ-ын дарга Ц.Баярбат,  
Хархорин сумын Засаг Дарга Г.Одгэрэл, Иргэдийн хурлын дарга Д.Гантөмөр,  
Өвөрхангай аймаг: Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Ч.Гүнсэнхорол, Барилга, хот  
байгуулалтын газрын дарга Т.Ариунболд, ерөнхий архитектор Г.Түвшинтөр,  
Архангай аймаг: Хөгжлийн банкны ерөнхий захирал Амаржаргал, Газрын харилцаа  
барилга хот байгуулалтын газрын дарга Отгонжаргал, Л.Архангай аймгийн ерөнхий архитектор  
болон албаны холбогдох бусад хүмүүс,  
Гүйцэтгэгч байгууллага болох Нийслэлийн Хот төлөвлөлт судалгааны институт  
ОНӨААТҮГ-ын багийнхан оролцов.

### **Хэлэлцсэн асуудал:**

Орхоны хөндийд шинэ хот байгуулах байршлыг судлан сонгох ажлын тухай.

### **Хэлэлцсэн нь:**

**Д.Тогтохсүрэн** : УИХ-с Орхоны Хөндийд шинэ хот байж болох асуудлыг судлах, санал боловсруулах ажлын хэсэг томилсон. Ажлын хэсгийн ахлагчаар би томилогдон ажиллаж байна. Манай ажлын хэсэг дэргэдээ мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын дэд хэсэгтэй. Энэ дэд хэсгийг нь Засгийн газрын гишүүн, Барилга хот байгуулалтын сайд Мөнхбаатар ахлана. Заа тэгээд нилээн олон бараг 10 хэдэн яам, Шинжлэх ухааны академи, Археологийн хүрээлэн гэх мэт газрууд орно.

Бид хэд хэдэн удаа ярилцаад энэ хоёр аймгийн мэргэжлийн хүмүүсийг байлгаж байгаад газар дээр нь ажиллъя гэж шийдсэн. За энэний дагуу Хархоринд ирээд байна. Монгол Улсын хөгжлийн дунд харилцааны хөтөлбөр, ирээдүйн хөтөлбөр “ Алсын хараа 2050” дээр Орхоны Хөндийд хот байна гээд орчихсон. Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт мөн орчихсон.

Үүнтэй холбогдуулж их хурлын шийдвэр гарсан. Үүний дагуу энэ жил бас улсын төсөв барилга хот байгуулалтын багцад туссан төлөвлөлтийн ажлууд хийгдэж байна. Орхоны Хөндийн хот байгуулалттай холбоотой асуудал зөвхөн энэ жил шинээр яригдаж байгаа асуудал огт биш, өмнө нь бас хэд хэдэн удаа яригдаж байсан асуудал. Миний мэдэж байгаагаар бол өмнө нь 2003, 2004 оны үед Хот байгуулалтын хүрээлэн, Энхбаярын Засгийн газрын үед 2000-2004 онд Хот байгуулалт хүрээлэнгийн захирал байсан хүрээлэн тэр үед бүсчлэлийн үзэл баримтлал гэдэг юм гараад, Хархорины хангайн бүсийн төв гэж энэнтэй холбогдуулаад нэг том төлөвлөлт хийсэн. Дараа нь 2012 онд Орхоны Хөндийд ажиллаад, бас тодорхой хэмжээний санал дүгнэлт боловсруулсан.

Эд нар архитекторын дүгнэлт гэхээсээ илүүтэйгээр хот байгуулах үндэслэл талаас нь илүү харж, дүгнэлтүүдээ гаргасан байна лээ. Өмнө нь ийм 2 том судалгаа явагдсан. Тэгээд манай ажлын хэсгийнхэн ярилцаж байгаад өмнө гарсан судалгаа мэдээлэл дээр дүгнэлт хийх нэг дэд ажлын хэсэг гаргаад ажилласан. Баярбатаар ахлуулсан. Ажиллах явцдаа Шинжлэх ухааны академи, соёлын яам тэгээд бас тодорхой хувь нь ярилцсан. Бид нарт одоо 3, 4-н том асуудал байна.

Хамгийн том шийдэх ёстой асуудал бол газрын асуудал. Хаана байх вэ? Ямар хүрээнд байх вэ? Энэ хүрээг эхний ээлжинд шийдэхгүй бол одоо нийслэлийн хот байгуулалтын хүрээлэнгийн хийж байгаа ажилд ч гэсэн яваандаа асуудал үүсэж болзошгүй. Бид нар юмаа их хурдан тодорхой болгож чадахын бол Ерөнхий сайд өөрөө нэг ирье гэж байгаа. Уул нь яараад яахавдээ гэсэн боловч 6-р сарын 30, 7-р сарын 1-нд Өвөрхангай аймаг, Архангай аймагт ажиллахыг төлөвлөж байсан. Энэ хүрээндээ Орхоны Хөндийн бүс нутгийг үзэх, бас энэ хот байгуулалтын хүрээнд хийгдсэн, ажлуудыг үзэж танилцах, ийм зорилгоор явъя гэсэн. Тэгээд өнгөрсөн долоо хоногоос яаруулаад байсан боловч өчигдөр яриад хойшлуулсан. Гэхдээ 8-н сараас хэтрэхгүй болов уу гэж бодож байна. 7 сар мэдээж чадахгүй, 7-р сар бол найр наадмын сар явж чадахгүй. 8 сард бол яахав, тэрнээс нь өмнө бид нар нэг ерөнхий чиг хандлагаа тодорхойлсон байх ёстой гэж бодож байна.

Өнөөдрийн тухайд бол би ингэж бодож байна. Дараа нь мэргэжлийн хүмүүс нь саналаа хэлнэ бизээ. Эхлээд хэдүүлээ Архангайнхан Өвөрхангайнхан бас мэргэжлийн хүмүүс маань энэ зурган дээрээ ярилцаад, байршлаараа ярьвал яасан юм бэ? Бусад ямар асуудал байна тэрийгээ энд 1, 2 цаг ярилцъя. Манай мэргэжлийн хүмүүс юу гэж санал хэлэх вэ, хойшоо явж, хэдүүлээ газар дээр нь очиж ярилцъя. Ингэж л бодож байна. Та бүгдэд ярих юм байгаа болов уу гэж бодож байна.

**Ц.Баярбат:** Би товчхон ярья. Заа бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тогтосүрэн дарга бүгдийг базаад хэлчихлээ. Бид нарын өнөөдрийн ажлын зорилго бол Барилга хот байгуулалтын сайдын багц, төсөвт батлагдсан хөрөнгөөр Орхоны Хөндийн шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судлах сонгох, боловсруулах гүйцэтгэгчээ сонгон шалгаруулаад ингээд ажиллаад эхэлсэн явж байна. УИХ дээр ажлын хэсгээс дэд ажлын хэсэг гэж байгуулсан гээд та бүхэнд өмнө нь хэлсэн. Тэгээд энэ гүйцэтгэгч тодорсонтой холбогдуулаад бид өнөөдөр бас газар дээр нь ирж өмнө нь хийгдэж тодорхойлсон ажлуудынхаа юмаа мэргэжлийн хүмүүстэй нь ирж үзэж харж танилцаж явж байна. Бид нар өмнө нь хийсэн судалгаа юмнууд Орхоны Хөндий, Архангай, Өвөрхангай аймгийн сумдын нутаг дэвсгэрийг хамарсан байршлыг урьдчилан тогтоосон. Түрүүн Тогтохсүрэн дарга хэллээ. Бас ер нь хуучин хот байгуулалт, Саидгуай төрийн өмчит газар байх үеэс би бас өөрөө эндээ ажиллаж байсан. Энэ үеэс нь бас мэдэх юмаа. Тэр үед агентлагтай байсан, одоо яамандаа ажиллаж байна.

Хархорин бол түүхэн газар байршдаг. Тэгээд Тогтохсүрэн даргын хэлснээр 3, 4 ч судалгаа хийгдсэн. За өнөөдрийн бидний сонгочихоод байгаа гүйцэтгэгч нь Нислэлийн Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ улсын хэмжээнд байгаа институтын статустай, бүтэц бүрэлдэхүүн хамгийн томтой ийм байгууллага маань сонгогдсон. Өөрийнхөө бүрэлдэхүүнээр судалгааны ажлаараа ингээд, ажиллаж байгаа гэсэн үгээ. Нийслэлийн хүрээлэнгийн хувьд бас эндээс бид ажиллуулж байгаагийнх нь учир шалтгаан болохоор түрүүний хийсэн, өмнө нь хийсэн судалгааны дотор хүрээлэн өөрөө орж хийсэн судалгаа байгаа энэ нь 2009 онд. Тэгэхээр энэ тал дээр судалгааны суурьтай байгууллага ирж ажиллаж байгаа гэдгийг юун түрүүнд хэлье. Энэ нь юу вэ гэхээр Хархорин, Эрдэнэзуу орчмыг одоо хот төлөвлөлтийн орчин үеийн аргаар жуулчдын төв хот болгон хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж байсан ийм байгууллага. Энэ байгууллага маань энд ирж ажиллаж байгаа шалгаан нь энэ шүү. Ажиллах болсон бас сонгогдсон нь бид нарт их түүхэн холбоо гарч ирж байгаа.

Түүнээс гадна гүйцэтгэлд шалгараад орон нутагт ажиллаж байгаатай холбогдуулаад Архангай, Өвөрхангайн холбогдох бас энэ асуудлыг хариуцдаг орон нутгийнхан маань энд тосож уулзаад, хүлээж авч байгаад талархал илэрхийлье. Юун түрүүнд ЗДТГ, хөгжлийн асуудал эрхэлдэг хүмүүс маань ирсэн байна. За манай газрын харилцаа, барилга хот байгуулалт, ерөнхий архитектор гээд яг үндсэн асуудлын талаар бидэнтэй санал солилцож, хэлэлцэж зөвлөлдөх хүмүүс нь ирсэн байна гэж ойлгож байна.

Яамны зүгээс сайд өөрөө ажлын нөхцөл боломж болоогүйн улмаас ирж чадсангүй. Сайд бол ирэх хүсэл эрмэлзлэл нилээн байлаа. Тийм учраас би яамдыг төлөөлж ирчихээд байгаа. Хариуцаж байгаа ажлын даргын хувьд. За мөн манай харъяаны 2 газраас газар зохион

байгуулах, Геодизийн газраас хот байгуулалтын хэлтсийн дарга Одбаатар, Барилгын хөгжлийн төвөөс хүн амын нутаг суурьшлын бүс хариуцсан хэлтсийн дарга Давааням маань ирсэн байгаа.

Энэ хүмүүс маань ирж ажиллаж байгаа нь ер нь сайн. Орхоны Хөндийн судалгааны ажил гэхээсээ гадна манай яам хүн амын нутагшлын ерөнхий төслийн томоохон баримт бичиг боловсруулсан. Энэ бүх юмтайгаа цогцоор нь харж үзэх гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээ ирж та бүхэнд бас ямар санал байна сонсьё.

Хоёрдугаарт мэдээж тухайн газар орон дээр амьдарч байгаа ажиллаж байгаа та бүхний санал бид нарт бас их чухал байгаа гэдгийг хэлье.

Тэгээд хүрээлэнгийнхэн Ганзориг та хэд маань товчхон танилцуулга хийх нь байх тийм үү. Бид нарын өмнө нь хийсэн танилцуулга эднийд ер нь нэгтгэгдчихсэн байгаа учраас, эдний хийх танилцуулгыг сонсоод, санал байгаа боловуу гэж бодож байна. Ийм байдалтайгаар Тогтохсүрэн дарга дээр ажлын хэсгийн бүх юмнуудаа ярьсан байгаа учраас гүйцэтгэгч маань бас ямар асуудлыг тодорхойлж байна вэ эхний байдлаар ямар байгаа, энэнээс хойш хэд хэдэн үе шаттай болоод явнаа. Бас бид байнга холбоотой ойр ажиллах зорилготой байгаа гэдгээ хэлье. За тэгээд хүрээлэнгийнхэндээ шилжүүлээд өгье.

**Т.Ганзориг :** За сайн байцгаана уу? Би хот төлөвлөлт судалгааны институтын ерөнхий инженер Ганзориг. Манайх 12 хүний бүрэлдэхүүнтэй баг ирээд ажиллаж байна. Хот төлөвлөгч архитектор, археологич, түүхч, газар зохион байгуулагч гэх мэтчилэн мэргэжлийн улсууд багаараа ирээд ажиллаж байна. Бид өчигдөр өдөр ирээд зүүн талаас нь эхлээд 2 байршлыг үндсэндээ зураглалыг нь гаргаад, мэдээллүүдийг цуглуулаад тойроод явж байгаа. Дөнгөж одоо эхэлж байгаа болохоор бид та бүгдийн саналыг нэгтгэж авна, бас хагассайн хүртэл 2 хоног судалгаагаа хийх ёстой. Судалгааныхаа хүрээнд байж болох бүх газруудаа судлаад, газар дээр нь судалгаагаа хийгээд, эхний тайлангийнхаа хүрээнд тодорхой даалгаврынхаа дагуу гурван байршлын саналыг боловсруулаад, мэдээллүүдээ өгөхөөр бэлтгэж байна. 7-р сарын 8-нд бид нар эхний тайлангаа өгнө. Ийм хэмжээнд ажлууд явж байна. Явцын дунд бид нар зураглал дээрээ аль байршлуудаар явсан гэдгээ танилцуулъя.

Одоогоор дөнгөж эхэлж байгаа болохоор дүгнэлтийн хэмжээнд очих болоогүй байна. Зурган дээр л явчихъя. Дэвсгэр зурган дээр бүх мэдээллүүдийг нь оруулсан. Орхоны Хөндийд шинэ хот байгуулах орон зайн дүн шинжилгээ урьдчилсан байдлаар судалгаа хийгдсэн байгаа. Ерөнхийдөө бодлогын баримт бичгүүд дээр бол Нийслэлийн баримжаатай хотыг Орхоны Хөндийд шинэ хот Хархориныг оролцуулаад, баримт бичгүүд гарсан байдаг. Энэ болохоор “АЛСЫН ХАРАА 2050”, Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын 2021-2025 онд үзүүлэх таван жилийн үндсэн чиглэл. Энэ нь одоо урт болон богино хугацааны баримт бичгүүд дээр энэ Орхоны Хөндийн шинэ хотын бүсийн суурьшлын байршлыг судлахаар 2050 төсөл дээр бол шинэ нийслэл Орхоны Хөндийн шинэ нийслэлийг боловсруулж техник, эдийн засгийн үндэслэл хөгжлийн шинэ төлөвлөгөө боловсруулж, бүтээн байгуулалт хийх ажлууд хийгдэнэ гэсэн хөтөлбөр байж байгаа. За тэгээд бид хэд бол энэ судалгааг анх хийхдээ Орхоны Хөндийг ямар түвшинд авч үзэх вэ? Энэ нь өөрөө хаана байх вэ, газар хэл хязгаарыг нь гаргасан байгаа. Энэ хил хязгаарыг нь гаргахдаа ойролцоогоор 110км, 1,4сая га газрыг хамарсан энэ талбайг сонгож аваад, түүн дээрээ орон зайн дүн шинжилгээ хийсэн. За ингээд эхний судалгааг хийхэд дэд бүтцийн талаар тендерийн буюу дэд бүтцийн хүртээмжийн талаар судалгаа хийсэн. Хархорин хот нь маань өөрөө нисэх онгоцны зурвас газартай. Гэхдээ энэ нь ангиллын хувьд 1-с цаашаа дээшлүүлэх шаардлагатай байгаа боловч нэг давуу тал болж байгаа гэж үзэж байгаа. Монгол улсын цахилгааны сүлжээнд холбогдох хэмжээнд нь төлөвлөж байгаа одоо юу гэдэг юм бэ 220-н киловатт өндөр хүчдэлийн шугам Хархорин хотыг дайран өнгөрөхөөр, ойролцоогоор дайран өнгөрөхөөр Орхоны Хөндийг дайран өнгөрөхөөр төлөвлөгдсөн байгаа дэд бүтцийн хүртээмжийн хүрээнд бас ийм боломжит хувилбарууд гарах боломжтой юм байна. 440, 220, 110-н шугам маань бас энд ирчихсэн байгаа. За ингээд Монгол улсын харилцаа холбооны шугамын хувьд энэ манай шилэн кабелийн

сүлжээнд ер нь орчихсон хэмжээнд явж байгаа. Заа тэгээд Орхоны Хөндийн байршлыг бид тодорхойлоод ирэх ойрхон байгаа сум сумдын суурин газруудын байршлуудыг ерөнхийд нь тодорхойлсон байгаа. Хархорин, Өгий нуур, Өлзийт, Хотонт гэсэн төлөвлөж байгаа 220-н өндөр хүчдэлийн шугам маань хотыг оролцуулан дайран өнгөрөхөөр Орхоны Хөндийг дайран өнгөрөхөөр төлөвлөгдсөн байгааг бас дэд бүтцийнхэн хүртээмжийн хүрээнд бас энэ боломжууд байдаг бас байх боломжтой юм байна. 440, 220, 110-н шугам маань бас энд ирцэн байна. Заа ингээд Монгол улсын харилцаа холбооны шугамын хувьд бол шилэн кабелийн сүлжээнд хэмжээнд орчихсон явж байгаа. Заа тэгээд Орхоны Хөндийн байршлыг бид тодорхойлоод ойр тойронд байгаа сум суурин газруудын байршлуудыг тогтоосон байгаа энд болвол Хархорин, Өгий нуур, Өлзийт, Хотонт гэсэн ийм хэмжээнд болохоор эхний ээлжинд авсан. Тэгээд 30 километр радиуст бол Хужирт, Батцэнгэл, Сант, Богд гээд сумууд орж байгаа.

50 километрын радиус дотор Төвшрүүлэх, Цэнхэр гээд сумдын төвүүд орж байгаа юмаа. Тэгэхээр суурьшлын бүсийн хувьд бол хот суурины хот, бүсчлэлийн хот, давхацлын хот нилээд нягтрал ихтэй байх боломжтой газар байнаа гэсэн тодорхойлолт гаргасан байна. Заа ингээд нийгэм, эдийн засгийн хувьд бол бид нар яг энэ хүрээлэлд багтаж байгаа сумдынхаа болон эдийн засгийн хувьд болон нийгмийн хүрээнд харьцуулалт хийсэн байгаа. За тэгээд ингээд одоо яг ингээд онолын дүн шинжилгээнийхээ хувьд ус цаг уурын нөхцлийн байдлын судлаад, цаг уурын станцтайгаа ингэж хамтарч гаргасан. Заа ингээд энэ дээрх чийгшлийн хувьд чийгшлийн хүйтэн 30-35 градус хүртэл хүйтэрдэг. Цасны ачаалал нь 55 кг/м<sup>3</sup> хүрдэг, хот байгуулахад ашиглагддаг ийм --- дундажаар бол тохиромжтой гэдэг ангилалд орж байна.

Усны нөөцийн хувьд бол ерөнхийдөө усны газартай хамтарч мэдээлэл авч гаргасан байгаа. Орхоны Хөндийн ойролцоо нийтдээ бол 5 газар судалгаа хийгдсэн байдаг юм байна. Үүнээс 1 нь болвол Архангай аймгийн Хашаат сумын усан хангамжийн зориулалттай 1995 оны үед хийгдсэн Гидрогеологийн судалгааны ажил маань батлагдсан нөөц бололцоотой маань дээд зэргээр 8.9-н 99литр/сек байхаар Төвшрүүлэх сумын төмрийн хүдэрлэгийн усан сан баяжуулах багийн гидрогеологийн судалгаа бас хийгдсэн байна. Энэний хүчин чадал нь 35,2литр/секундын хүчин чадалтай. Монгол улсын хангайн цэг буюу Хархорин сумын усны хангамж нэмэгдэж шинэ эх үүсвэрийн Орхоны голын хийгдсэн 2007 онд хийсэн судалгаа байж байгаа 1,25литр/секундын хүчин чадалтай байнаа. Цэцэрлэг хотын усан хангамжийн зориулалттай 1981 оны -- голын хэсэгт хийсэн газрын -- нь нарийсалтай 122 литр/секундын хүчин чадалтай буюу нөөцтэй. Архангай аймгийн төв Цэцэрлэг хотын өнөөгийн ус авах байгууламжийн сав бүсэд 2011 оны усны судалгаагаар бол нийт 66 литр/секунд хүчин чадалтай усны илэрцүүд илэрсэн байна. За энэ саяны -- Хөрс ургамлын хувьд бол ургамлын бүтэц болон хөрсний бүрхэвч нь төлөв байдлаар нь бид нар бас шинжилгээ хийсэн. Энэ маань бол ерөнхийдөө бид нар 500,000-1,500,000 масштабтай зураглал дээр хийсэн. Ерөнхийлсөн хийсэн гэсэн үг. За ингээд нөгөө -- дээр --- байнаа

Заа энэ геологийн үндэслэл дээр бас 500,000-1,500,000 масштабтай зураг дээр үзэн тохиромжтой болон хагас тохиромжтой, хязгаарлагдмал тохиромжтой гэсэн үнэлгээг гаргасан байгаа.

Газар хөдлөлийн мужлалыг тодорхойлох буюу газар хөдлөлийн мужлалын зургаар бол ерөнхийдөө Монголын газартай ойртох тусам газар хөдлөлийн байгалийн эрч нь бол нэмэгдэж байгаа 8 хүртэлх баллын ийм хэмжээнд энэ бүс нутагт хамрагдаж байнаа гэсэн үнэлгээ өгөгдсөн.

Заа ингээд газрын гадаргын өндөржилт, залуужилтийн хувьд яг ингээд хийгдэхэд бол Орхоны Хөндий маань өөрөө яг ийм сунгасан квадрат төрөлд бол тохиромжтой болон нэн тохиромжтой гэдэг ийм бид нарын гаргасан том масштабтаар гаргасан ийм үнэлгээ байнаа. Заа ингээд үерлэлт, намжилт хөрсний усныг бол бид нар сансрын зургийг ашиглан, цаг хугацааных нь үечлэлээр ингэж авж үзсэн байгаа. Эндээсээ бол тодорхой хэмжээгээр хязгаарлагдмал буюу тохиромжтой сайр, ус, намхархаг газруудаа хасаад ерөнхийдөө бол татсан бид нарын тооцоотой гаргаснаар бол тохиромжтой.

Өгий нуур орчим тэгээд нөгөө Орхоны Хөндийн бусад газраас гарсан. За тэгээд эндээсээ бол дэлхийд өвд бүртгэгдсэн газар байдаг. Энэ маань 129, 967га газар, энэ маань бол тодорхой хэмжээний бид нарын сонгосон тохиромжтой гэдгээс таллаад ингээд урд талын хэсэгт маань ингээд хамрагдаж явж байгаа. Энэ нөгөө Дэлхийд өвд бүртгэгдсэнтэй холбоотой эндээс тавигдах шаардлага энэ нөхцлүүдээс хамааруулаад энэ маань өөрөө ганцхан, энэ боломжууд нь багатай байна гэдэг нь хасагдахаар ойролцоогоор төлөвлөлтийн процессууд маань яг энэ боломжтой гэдэг талбайг 2 байршил дээр Орхоны судалгааг гаргаж болно. Ингээд ерөнхийдөө Орхоны Хөндий буюу Орхоны хөндий гэдэг талбай дээр бол яг энэ хэсэг дээр энэ маань болвол Шинэ хотын байршлын хувьд нутаг дэвсгэрийн хувьд биш хотжилт үүсгэх хотжилтыг дэмжих 34,771 га газар бол ерөнхийдөө хязгаарлагдмал тохиромжтой болон тохиромжтой гэж үнэлэгдэж гарсан байна.

За ингээд нөгөө нэг саяны нөгөө дэлхийн өвөөс хасагдсан талбайг нь хасаад харахад 26,485га газрыг одоо жишээлбэл ойролцоогоор хамгийн тохиромжтой хот суурин газар гэж тогтоох боломжтой юм байна гэсэн урьдчилсан байдлын байршлуудаар ингэж тогтоож байгаа.

**Ц.Баярбат :** Сая та бүхэнд ажлын хэсгийн хүрээнд хийгдсэн одоо бид нарын ерөнхий судалгааг газрын байршлыг урьдчилсан байдлаар тодорхойлох судалгааны багц танилцуулгыг хийлээ. Та бүхэнд одоо гүйцэтгэгч маань ажлаа цаашид илүү нарийвчилсан судалгаануудаа хийж тодорхойлох ажилдаа орно. Заа тэгээд хот байгуулалтын газруудаас тохиромжтой юу үгүй юу гэдэг үнэлгээнүүдээ бас хийгээд төлөвлөгөөрүүгээ орно гэдэг ийм ерөнхий даалгавартай ажиллаж байгаа. Энэ хот байгуулалтын маш олон төрлийн судалгаа шаарддаг. Энэ чинь өөрөө хот байгуулалтад өөрөө бүх асуудлыг багтаасан, цогц аян байдаг. Тэгэхээр энэн дээр бид нар бол ул суурьтай хандаж ажиллах үүднээс ийм мэргэжлийн байгууллага ажиллаж байгаа гэдгийг хэлье.

**С.Давааням:** Барилгын хөгжлийн төвийн, ажлын хэсгийн Давааням байна. Манай дээр сүүлийн 4 жил Шинжлэх Ухааны Академиуд, Их дээд сургуулийн судлаачид, мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор 4 дэх жилдээ экономийн суурьшлын хөгжлийн хот төлөвлөлт дээр ирэх 20 жил монгол улсын хүн ам суурьшилт, хотжилт, хот байгуулалтын, хөгжлийн орон зайн төлөвлөлтийн зураглалыг гаргах энэ одоо баримт бичиг дээр ажиллаад, төсөл дээр ажиллаад намар гэхэд Засгийн Газар, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр төлөвлөж байгаа. Одоо бол яамдууд хэлэлцээд, санал авах түвшинд явж байна. Дараагаар нь албан ёсоор санал аваад ингээд хэлэлцүүлээд явна. Бас дараа нь бас Тогтохсүрэн гишүүнд ч гэсэн тусад нь бас цаг авч байгаад энэ талаараа бас тухайлбал Өвөрхангай аймаг болоод Монгол улсын хувьд орон зайн зохион байгуулалт, хот төлөвлөлт хийнэ гэдэг бас л ямар хувилбар саналтайгаар боловсруулж байгаа юм бээ? гэж танилцуулъя гэсэн төлөвлөгөөтэй байна. За Өвөрхангай аймгийн хувьд болохлоор бас Монгол улс ерөнхийдөө засаг захиргааны бүтцийн хувьд бас дэлхийн ихэнх орнууд хот гэдэг нь хоёр ялангуяа хоёрдогч хот нь засаг захиргааны бие даасан статустай гэж, гэтэл манайд 100,000 хүнтэй хот нь 1,000 хүнтэй мал аж ахуй давамгайлсан тийм сумтай, адилхан статустай. Дээрээс нь бас хот төлөвлөлтийн хүрээнд бас нэг саналын хувилбарыг төлөвлөөд байгаа нь юу вэ гэхлээр Хархорин хот, Замын-Үүд хот 2-ыг бас улсын зэрэглэлтэй стратегийн ач холбогдолтой засаг захиргааны биеэ даасан хот болгож, төлөвлөж хөгжүүлэе гэж байгаа юм. Яагаад вэ гэхлээр

**С.Давааням:** Бусад аймгууд нь өөрсдөө аймгийн төв засаг захиргааны чиг үүрэгтэй. Аа гэтэл Хархорин, Замын-Үүд 2 албан ёсны бүртгэлтэй хүн амын тоогоороо 12,000-с 18,000 хүнтэй, хөдөлгөөнт тоог нь нэмэх юм бол бас 15,000-20,000 болчихдог, аа гэтэл эдгээр хотууд нь сүүлийн 30 жил бас энэ сум статустай ингээд яваад ирсэн, тэгэхээр бид нар бас олон улсын хот төлөвлөлтийн хөгжлийн орон зайн зарчмын дагуу. Жишээлбэл Хархорин хот бол стратегийн чухал ач холбогдлыг нь харгалзаад Монгол улсын бүх сум, суурин газартай хамгийн ойр зайтай байгаа, өөрөөр хэлбэл Монгол улсын бүх сум, суурин газруудаас төлөөлөх хурал семинар хийеэ гэхэд энд бол хамгийн хямд зардалтайгаар хүрч ирэхнээ, заа нөгөө талаар бас энэ Хархорин хот маань түүхэн хот аялал, жуулчлалын болоод тэ түүх соёлын болон түүхийн стратегийн ач холбогдолтой бүс нутаг учраас энийг бас дэвшүүлэе. Өөрөөр хэлбэл одоо

Хархорин хот бол зөвхөн Өвөрхангай аймгийн сум биш юмаа, Монгол улсын сум юмаа бас нэг түүхэн соёлын ач холбогдолтой бүс нутаг юм гэж үзэж байгаа юм.Замын-Үүдэд өнгөрсөн 30 жилд хүн амын цэвэр өсөлтөөрөө Монгол улсын хотуудаас хамгийн 1 дүгээрт орсон. Эрээн хот ямар статустай хөгжиж байгаа билээ гэдгийг бас Замын-Үүд хот бол зөвхөн Дорноговь аймгийн нутаг биш юмаа, Монгол улсын Зүүн хойд Азийн гадаад худалдан авалт, тээвэр логистикийн том том боомт юмаа гэж үзээд энэ ярьж явж байгаа. Энэ байршил дээр бол бас бид нар одоогийн Хархорин сумын одоо суурьшлын сумын төвийн одоогийн суурьшлын бүс маань хүн амын нягтаршлаар аймгийн төвүүдээс 5-с, дундажаар 5 дахин бага, өөрөөр хэлбэл магадгүй энэ судалгааны баг ч гэсэн яваандаа дүгнэлт гаргах байх. 40,000-50,000 хүнтэй суурин газар одоо байгаа суурьшлын, одоо нөгөө дэлхийн өв болоод бусад газруудыг хамруулахгүйгээр өмнөхөө сайжруулаад төлөвлөлтийн хувьд 40,000-50,000 хүнтэй Азийн хот болж, хөгжих боломжтой. Мэдээж энэ нь бол ойрын зорилт , төлөвлөгөөгөөр шийдэж болно. Мэдээж дараагийн байршил нь болохоор газар тариалан дүрслэгдэх байх тэ, тэгээд дээрээс нь Дэлхийн өв Орхоны хөндийд тусгай хангайн нурууны дархан цаазат газар гээд байгаа учраас одоо 100,000-с дээш буюу хэт том хот байдлаар хөгжихөд газрын нөөц даац нь харьцангуй хязгаарлагдмал байгаад байна. Яахав Монгол улсын хувьд харьцангуй цөөн хүн амтай бас эдийн засгийн боломж тэдгээрийг нь харгалзаад яахав богино хугацаандаа юмуу дунд хугацаандаа Хархориныг одоогийн суурьшлын хэмжээнд хот төлөвлөлтийг нь сайжруулвал магадгүй 40, 50 мянган хүнтэй болоод, цаашлаад болоод Өгийнуур сумын нутаг, Өгийнуур сумын төвөөс зүүн хэсэг нь буюу одоо энэ Дэлхийн өв энэ газраас, хилийн зэсний хойд бүс нутагт хүртэл 40, 50 километр байгаа байх тэ. Улаанбаатар хот чинь одоо Багахангай, Багануур 2 чинь хэдэн километр байгаа билээ? 100-с дээш километр гээд явж байгаа. Зүүн урагшаа гадаргын усны нөөц байхгүй. Судлаачийн хувьд ийм саналтай байна. Тэгэхээр мэдээж аливаа том хот чинь өсч хөгжихдөө үе шаттайгаар ингэж явах учраас бас тийм саналыг бас хэлж байгаа юмаа.

**Ц.Баярбат :** Баярлалаа. Ганзориг даргыг сонсьё.

**Т.Ганзориг:** Өчигдөр бид нар судалгааныхаа ажлыг эхлээд хуучин байршил сонгож байсан сум одоогийн Хөшөөт байгаа. Та бүхэн мэдэх байх.

**Ц.Баярбат :** 8,300 байгаа гээд байсан.

**Т.Ганзориг:** Судалгааныхаа нэг хэсэгт оруулах гээд очоод

**Т.Ганзориг:** За тэрийгээ бас тохиромжгүй гэж үзсэн боловч, энэ нь бас яагаад тохиромжгүй вэ гэсэн. Тэгээд хойшоогоо яваад Өндөрмааньт, Тэрхийн цагаан нуур гэсэн орчмын энэ байршлуудыг эхний ээлжинд харахдаа бол өндөржилтийн байрлалаар газрын налуу гээд налуужилтын байдал нь бол тохиромжтой байх гэдгээр нь хүрээ татчихаад, одоогийн эхний бай бол судалгааны хүрээлэн учраас газар дээр нь очиж үзээд тодруулга хийгээд явж байгаа. Заа ингээд зүүн талаасаа эхлээд бид нар энэ байршлаа харчихаад, тэгээд буцаж ирээд үдээс хойш Хархорин дээрээ Хархориныхоо бас одоогийн байдлыг зурагжуулаад, дрон бичлэг аваад, судалгааны зураг аваад, одоогийн суурьшлын бүсийн судалгааны нэг хэсэгт орсон. Соёлын баримт, өнөөгийн нөхцлийг судалгааныхаа нэг хэсгийн баримтанд оруулна. Тэр хүрээндээ Өчигдөр үдээс хойш бид нар Хархориныхоо судалгааг хийгээд, Өнөөдөр өглөө гараад болохлээр зэрэг болон цогцолборуудаар явсан.

**Д.Тогтохсүрэн:** манайх чинь уг нь тохиромжтой, тохиромжгүй гээд л гаргадаг.

**Т.Ганзориг:** Хөшөө цайдам, Хүрэн чулуут орчмоор бас сая бас өглөө судалгааныхаа ажлыг хийгээд бичлэг, дроноо нисгээд судалгаагаа хийгээд явлаа. Заа одоогийн байдлаар бол ногоожилт болон орчны газраар тохиромжтой гэсэн зураг дээр харсан байршлуусаа 2 байршлыг нь бэлдчихсэн байна. Цаашаа ахиад 2 хоног судлаад Баруун талаа дагаад, тойрно. Одоогоор бол бид нар үнэлт, дүгнэлт нэн тохиромжтой гэсэн байрлал байхгүй. Одоо бол дөнгөж нөгөө үндсэн зураглалуудыг гаргасан явж байгаа. Зураглалуудыг хараад газар дээрх эхний судалгаа хийгдэж байгаа болохоос одоо бид нар бүх судалгаагаа нэгтгээд хотод очоод, судалгаанууд дээрээ дата үнэлгээ гаргаад, үнэлгээн дээрээ суурилоод, энэ байршлууд нь ямар нөхцлүүд гарч ирж байна вэ гэдгийг нарийвчилж гаргаж өгнө. Эхний байдлаар 7-р сарын 8 нд

хүргүүлэхээр ажиллаж байгаа. Одоогийн байдлаар үнэлэлт , дэгнэлтэнд хүрэн болоогүй байгаа. Заа манай бүрэлдэхүүнд бол ер нь бас туршлагатай хүмүүсээ оруулна гэсэн байдлаар, жишээ нь зөвлөхүүд оруулж ажиллаж байгаа, зураг төслийн хүрээлэн гээд манайд ажиллах байгаа хүмүүсийн хязгаарлалт. Дэлхийн өв д бүртгүүлсэн гол ажлуудыг хийж байсан хүн бас байгаа. Манай хүрээлэнгийн Нарангэрэл, хот төлөвлөлт, архитехторын зөвлөл. Манай түүхийн талаасаа Батсайхан гээд туршлагатай түүхч, гаднаас зөвлөхөө аваад ажиллаж байгаа. Бусад нь бол манай залуучууд, ганц нэг хүрээлэнгийн ажилчдын хамт явж байна. Аа хүрээ нь бол нилээн өргөн хүрээтэй учраас зөвхөн хүрээлэнгийн улстай хязгаарлахгүй гээд өргөжүүлж, одоо ажиллаж байна.

**Г.Нарангэрэл :** Одоо бид нар энэ байршлуудаа эхлээд судлаж байна. Эхний байдлаар налуужилтын байдлаа гаргана. Тэгээд дараа нь биднүүс тохиромжтой гээд нөгөө хил талбайнуудаа тодорхойлоод гараад ирэхлээр зэрэг талбай маань өргөсөөд гараад ирэх байх. Тэгэхлээр зэрэг одоо бол бид нар энэ байршил, энэ байршил 2-оо үзчихээд байгаа юм. Дөнгөж 2 байршил. Тэгээд 2 байршил үзчихээд дахиад одоо бид нар 2 хоног тойрохдоо үлдсэн байршлуудаа бүгдийг нь нягтлаад, заа энд дэлхийд бүртгэгдсэн гэдэг талбай маань ерөнхийдөө бол бидний төлөвлөлт хийх талбайнаас хасагдаж, хасагдчихаад байгаа юм. Заа ийшээ болохлээрээ бас

**Т.Ганзориг:** Хангайн нурууны цогцолбор газар гээд тэр бараг энэ Бат-Өлзий гээд тэр чигээрээ бараг шахуу орчихдог юм байна лээ. Тэгэхлээрээ зэрэг Бат-Өлзийрүү судалгаа хийхэд, үр дүнгүй болчихож байгаа юм. Тэгэхлээр зэрэг хойшоогоо бол Орхоноо дагаад энэ хойд талын чигээ зүүн чигээ, ингэж барьсан байдлаар зүүн болон хойд чигээ ерөнхийд нь...

**Д.Тогтохсүрэн:** Би бол ингэж бодоод байгаа байхгүй юу энэ энэ энэ эрэг нь 8-н сум агуулсан том судалгаа бол би бол хийх шаардлагагүй байх гэж бодоод байгаа юм даа. Эхний ээлжинд 26мян/га газар дээрээ л судалгаа юмнуудаа хийвэл яасан юм бэ? Хэт өргөн болоод ирэхээр хөрөнгө мөнгө ч нилээн шаардах байх, 2-рт жоохон ерөнхийдөө болчихнуу гээд бодоод байгаа. Цаашдаа ингээд бид нар энэ бол ингээд олон удаагийн яригдаж байсан талбайнууд учраас зөвхөн 26мян.га газар дээрээ судалгаагаа жаахан нарийвчилж хийлгэвэл яасан юм бэ? гэж бодож байна.

**Т.Ганзориг :** Болно болно.

**Д.Тогтохсүрэн:** Тийм юмаар 26мян.га-саа гараад явчихад тэртэй тэргүй өмнөх 2,3-н удаагийн судалгаагаар чинь болвол тэрний дүгнэлтээр болуул хот байх хамгийн бололцоотой нь 26мян.га газар байхгүй юу. Тэгэхлээр 26мян.га дээрээ одоо судалгааны асуудлаа ярьвал яасан юм бэ гэж би бодоод байна л даа. Танайх болуул өгөхдөө, танайх өгөхдөө зургийн даалгавартаа 5-н сум өгчихсөн, эд нар нэмээд 3-н сумын асуудал яригдаад ингээд 8-н сумын хүрээнд, аягүү том хүрээнд яваад байгаа байхгүй юу. Би бол зөвхөн 26мян.га газар чинь бол одоо юунд л байгаа шүү дээ. Хотонтын нутгаас нэг жаахан байгаа бага зэрэг. Архангай аймгийнхан байна. Хашаатын нутгаас нилээн бас нээх том биш. Хамгийн том нь Өгийнуурын нутаг том орж байгаа тэ. Өгийнуур том орж байгаа, тэрэн дотор нөгөө алдарт Өгий нуур нь өөрөө орчихож байгаа юм. Өмнөх 2,3 удаагийн судалгаагаар болвол тэрний дүгнэлтээр болуул хот байх хамгийн бололцоотой ны саяны 26мян.га газар байхгүй юу. Тийм учраас эд нар 26мян.га газар дээрээ л юмаа ярьвал яасын бээ гэж бодоод байгаа байхгүй юу.

**Ц.Баярбат :** Тийм, дарга юу байгаа юм - Ер нь өгсөн даалгавар бол зүгээр яахав би нэг Орхоны Хөндий 5 сумын нутаг дээр ер нь хамаарч байна. Даалгаврын өгөгдсөн обион бол ерөөсөө л энэ. Суурь судалгааг 2480га дээр, Хот байгуулалтын зүгээр үнэлгээгээ бол 2,485га дээр ингээд энэ хүрээндээ ТЭЗҮ-гээ боловсруул гэсэн даалгавартай юмаа. Тэгэхэр эд нарын маань үндсэн нарийвчлалыг харвал 26,480га тэгээд л хийгдэнэ. Яахав хот байгуулалт томоосоо жижигрүүгээ явдаг гэдгээр нь манайхан ажлаад, Орхоны Хөндийгөө бас ойлгох гээд явчихаж, явсан байна. Одоо эндээсээ бидний ярьж байгаа 26,480га дээрээ л бууна. Тэгж л ойлгож ажиллаж байгаа. Тэгээд яахав эхний судалгаа учраас тойрч үзэж, байгаа юм байна. Бид нарын хувьд бол хувилбаруудыг бас дотор нь сайн энэ дотроо хараарай гээд өгөдсөн байна.

**Д.Тогтохсүрэн:** Эд нар чинь юу билээ?

**Т.Ганзориг:** Эд нар очиж нягтлах талбайнуудтай холбоотой, ямар ч байсан очиж үзье. Хүрээ маань ийм том учраас бид нар 5 сумынхаа газар нутаг дээр ажиллаад байгаа байхгүй юу? Тэгээд асуудал нь юу байна гэхлээр даалгавар дээр 3-с доошгүй хувилбар гээд байгаа юм. Хувилбарт байршил гээд байгаа юм. Тэгэхээр зэрэг 1 байршил одоо эцсийн байгаа сонгогдсон ч, давхар 2 хувилбарт байршлыг нь бид нар санал болгож оруулах ёстой юм л да даалгавраар. Тэгэхлээр зэрэг бид нар энэ талбай ерөөсөө Орхоны Хөндийн талбай гэхлээр ерөөсөө энэ талбайгаас энэ бол бид нар нэмж харах уу гэж байгаа юм. Орхоны Хөндийгөөс арай жоохон салаад явчихаад байгаа юм.

**Д.Тогтохсүрэн:** Тэгээд одоо явж явж байгаад

**Д.Тогтохсүрэн:** Ганбаатаргуай энийг зурж байхад л та жоохон өргөн өгчихөж дээ.

**Ганбаатар:** Харин бага өгчихсөн ш дээ, Өгийнуур орох байсан юм. Энэ дэлхийн өвд бүртгүүлээд энэ галактикийн зургийг нь гаргаад явж байсан чинь Улаанбаатар Орхоны Хархорин хотоо оруулаад явж байсан чинь Дэлхийн өвд явуулчихсан юмаа. Тэгсэн чинь байж байгаад ирсэн чинь өө өнөөдрийн Хархорин хот чинь Дэлхийн өвийн статусын хэмжээнд биш байна аа. Өнөөдрийнхөө Хархорин хотыг шилжүүлэн нүүлгэх юмуу? Шилжүүлэн нүүлгэхгүй бол дэлхийн өвтэй яаж зохицуулах тэр менежмент нь байгаа юмуу? Энэ асуудлаа шийдэхгүйгээр Дэлхийн өв чинь авахгүй ээ гэсэн байхгүй юу? Тэгээд тэр асуудал нь айхтар том болоод, тэгээд тэр өнөөдрийн Хархорин хотыг тойрсон 10-н хэдэн юу чинь нэмж орж, ирээд тэгээд Дэлхийн өвийн газар нутгийн яг гол дунд нь байгаа мөртлөө, яг хуулийнхаа утгаар тойруулаад, хуулийн заалт хийгээд, тусгай хамгаалалтын газар нутгаас гаргачихсан. Тэгэхээр өнөөдрийн арга хэмжээнд бол Дэлхийн өвийн газар нутгийн гадна, байж байгаа. Тэгэхээр энэ бол маш их эрх бөгөөд энэ нөгөө Хархорин хотыг хөгжүүлэх бодлоготой чинь Дэлхийн өвтэй яаж зохицохов. Хэрвээ энэ дэлхий өөрөө их харшилбал өвийн асуудал айхтар хөндөгдөнө. Хархорин хотоо яаж хөгжүүлэх вэ? гэдэг чинь бас давхар яригдах ёстой тэгээд одооны шинэ суугчдын бүс бол эрсдэл ихтэй л юу байна. Тэгээд тэр тоглохын бол тэр хойшоо л одоо ямар байдаг юм бол судалж байгаа учраас эхний ээлжинд дүгнэлт хийх юм алга. Эхнээсээ л ерөөсөө тэгсэн судалж байгаа суурьшилд Дэлхийн хүн төрөлхтөний ганц нүүдлийн соёлын голомт нутаг, сүүлчийн нүүдэлчдийн голомт нутаг, дэлхий ерөөсөө ганц энэ энэ юмыг чинь л ерөөсөө харна. Тэгээд энүүнийг хадгалж, хамгаалж үлдэхийг Монгол одоо хариуцна л гээд тийм утгаар хэлээд байна.

**Эрдэнэбаатар:** Би Археологийн хүрээлэнгийн хүн биш боловч Улаанбаатар их сургуулийн археологич, түүхч, энэ багт ажиллаж байна. Энэ түүхэн уламжлалаа бодоод үзэхэд бол энэ Орхоны сав нутаг бол лавтай 2,500 жилээс өнөөдрийг хүртэл Монгол улсын нийслэл төв байсан хэвээр байгаа. Тэгэхээр бид нар түүхэн уламжлалаа бодоод үзэхийн бол энэ нутаг яах аргагүй тийм шинэ хотын төсөөлөлд байх бололцоотой. Тэгэхдээ сая Ганбаатаргуай хэлдэг ЮНЕСКО-гийн Үндэсний Соёлын өвд ингээд хамаг хил хязгаарыг нь өгцөн учраас одоо байгаа хамгийн боломжтой, саяны одоо Ганзориг даргын танилцуулсан тоглохын тал нийслэлийн талбайн гадна, гадна талбайнуудыг гэж үзэж байгаа юм. Бидний одоогийн урьдчилсан судалгаа гэвэл түүх соёлын болон археологийн ямар нэгэн дурсгал өртөхөөргүй ийм талбай. Хойд талын одоо тэр гурван том талбай. Аа тэр зүүн талын талбай эд нар болуул боломжийн ямар нэгэн түүх соёлын дурсгалууд өртөхгүй байх

**Д.Тогтохсүрэн:** Эрсдэлтэй гэдэг бол одоо дэлхийн өвд ойрхон байгаад байвал эрсдэлтэй, аль эсвэл өөрийн гэсэн шалтгаан байна уу

**Эрдэнэбаатар:** Тэртэй тэргүй Дэлхийн соёлын өвд байгаа Нара гээд Японы Нара гээд байгууламж судалгаагаа хийгээд явж байгаа. Хүний суурьшил хамгаалалт ойртох үед энэ хамгаалалт Шинжлэх ухаан судалгааны орчин сайжирна уу гэхээс муудаад байх юм байхгүй. Нүүдлийн соёл иргэншил болон суурин иргэшлийн тэр үнэт зүйл 2 чинь яаж авцалдах юм бэ гэдэг асуудлуудыг тавьж байгаа юм.

**Тогтохсүрэн:** Би бол Археологийн Хүрээлэн бол ингэж болно л гэж байна лээ. Дэлхийн соёлын өвийн тодорхой хэсгийг хот байгуулалтын газартаа оруулж аваад, хот байгуулалтын газартаа оруулж аваад тэгээд тодорхой хугацаанд бид нарт төлөвлөлт л хийгдэнэ. Тэр цаасан дээр тэгэхээр тодорхой хугацаанд археологийн хүрээлэн дэлхийн соёлын өвтэйгээ хамтраад,



археологи хийгээд, тэгээд дэлхийн соёлыг бас гаргаж болох уу? Өөрөөр хэлбэл одоо яг хот байгуулалтын үндсэн том газрууд чинь ний нуугүй хэлэхэд Дэлхийн соёлын өвтэйгээ бүгдээрээ очоод орцон байхгүй юу. Тэгэхээр энд уул нь археологийг нь хийгээд, байна уу үгүй юу гэдгийг нь тогтоогоод, за энэд болвол юунээс Дэлхийн соёлыг бас гаргаж болохын байнаа гэдгээ тогтоогоод зарим газрыг болвол чөлөөлмөөр байгаа байхгүй юу. Энэ бол хэт ингээд, өргөн оруулж хаяад Хот байгуулалтын газар ний нуугүй хэлэхэд байхгүй болгоцон байхгүй юу. Эсвэл бүүр 100км-н цаана тоглохын тал Өлзийтрүү очихоор болж байгаа байхгүй юу, тийн. Тэгэхээр болвол Археологийн Хүрээлэн бол тэгдэг юм байна лээ. Аа ер нь бол энэ газруудад бол төлөвлөлт хийж болно. Аа харин төлөвлөлт хийсэн газраа тодорхой хэсэгт Засгийн газар мөнгө гаргаад, Дэлхийн соёлын өвтэйгөө ярилцаад, Археологи хийлгэх ёстой. Археологио хийлгээд, археологи юу байна гэдгээ тогтоосны дараа энэнээс чөлөөлж болох ёстой гэж Археологийн Хүрээлэн бол тэгж байна. Энэтэй холбоотой асуудал. Дэлхийн соёлын өв газрын нэг хэсэг нь хотдоо орчихсон л байж байг. Одоо хэдэн га нь ч байдгийн, 10,000мян.га байдаг ч юмуу, 20,000га ч байдаг юмуу хотдоо орчихсон л байж байг л дээ. Тэн дээрээ хот байгуулалтын төвөллөлтийг хийчихээд л өөр юм хийхгүй байж байгаад л археологийн ажил хийснийх нь дараа гаргаж байж авна гэдэг зарчмаа гаргаад л явбал яасан юм бэ?

**Ганбаатар:** Зөвхөн археологи биш шүү дээ. Ганцхан археологи тэр газар доор байгаа нүүдлийн соёл иргэншлийн гэж тэ маш том агууламж

**Д.Тогтохсүрэн:** Хот байгуулалтын газар орж төлөвлөөд, явах хэрэгтэй гэж бодоод байгаа юм. Тэгэхгүй бид нар ингээд л орхивол одоо цаашдаа ингээд 26,000 үзэгдээд, одоо энэ 26,000 ингээд байхгүй болно. 26,000 дотор чинь бол Өгий нуур тэр чигээрээ орчихсон байна лээ. Өгий нуур хэзээ ч хот төлөвлөлтөнд орохгүй байхгүй юу. Тийн. Энэ иргэд хэзээ ч өгөхгүйшдээ хот төлөвлөлтөнд, тийн. Тэгэхээр энэ бол худлаа төлөвлөлт болох гээд байгаа байхгүй юу. Бид нарын ажил худлаа болох гээд аа харин тэрний оронд бодитой, яг хот байгуулах газраа төлөвлөлтөө хиймээр байгаа байхгүй юу. Дэлхийн соёлын өвийнхөн одоо Ганбаатаргауй бол уучлаарай Соёлын яамныхан бол одоо байнга энийг эсэргүүцдэг байхгүй юу. Аа Шинжлэх Ухаан Академи юу гэж үзээд байна вэ гэвэл Дэлхийн соёлын өвийн газар дахин төлөвлөлт хийж болно. Тэрийг нь газар хот байгуулалтын хүрээнд оруулж болно. Аа харин ганцхан дараа нь хот байгуулалтаа хийхдээ заавал археологийн судалгааг нь хийлгэж, өөр судалгаануудыг нь хийлгэж тогтоогоод бараг гаргаж байж юмаа хийх ёстой, хот байгуулалтыг хийх ёстой. Аа зүгээр юун дотор чөлөөтэй ш дээ гэж байгаа байхгүй юу?

**Д.Тогтохсүрэн:** Харин өнөөдрийн Хархориныг бол нар ерөөсөө хөндөхгүй байгаа ш дээ. Яагаад гэвэл Дэлхийн 1-р соёлын өвийн гол бүс нутаг. Аа дээр нь маш их олон одоогоор археологийн дурсгал дүүрэн байгаа энийг бол бид нар хөндөхгүй гээд байгаа Харихориноо бол тэгээд байгаа ш дээ. Өгий нуур дээр л байгаа байхгүй юу. Энэ төлөвлөлт шал буруу төлөвлөлт болох гээд байгаа байхгүй юу.

**Д.Тогтохсүрэн:** Гүй ээ би. Би бол ер нь ингэж л харж байгаа юм биш. Дэлхийн өвийн газраас тодорхой хэсгийг хот төлөвлөлтөнд л оруулчихмаар байгаа байхгүй юу. Тэгээд оруулсныхаа дараа шаардлага нь тэр Шинжлэх Ухааны Академийнхантайгаа ярьж байгаад л заавал археологи, юм хийж мийснийх нь дараа хот төлөвлөлтөө хийнэ. Тэгэхгүй бол заавал хот байгуулалт бол ямар ч үр дүнгүй явнаа л гэж, би бол ямар ч үр дүн муутай болох байхаа л гэж бодоод байх юм. Үр дүн муутай болох байхаа л гэж бодоод байх юм. Өгий нуур дээр хот төлөвлөнө гэдэг бол маш буруу.

**Эрдэнэбаатар:** Би бас Ганбаатаргауйтай яг энэ асуудлаар нилээн маргадаг юм. Тэгэхээр бид нар нүүдлийн гэдэг буруу нэр томъёо хэрэглэдэг, бид нар хэзээ ч нүүж байгаагүй, бид нар нүүдэлчид биш бэлчээрийн мал аж ахуйн соёлтой. Тэгэхээр яг одоо Ганбаатаргауйн яриад байгаа үнэн л дээ. Нөгөө бэлчээрийн мал аж ахуйгаа та нар яаж энэ Дэлхийн өвтэйгөө хадгалж хамгаалах вэ гэдэг асуудал яригдаад байгаа юм. Би бол судлаач хүний хувьд Тогтохсүрэнгауйтай яг санал нэг байна. Тэгэхээр одоо энэ талбайн хойд хэсэг бол үнэхээр археологийн судалгаа хийгээд, бие төв байвал ингээд судлаад барилгачдын талбай болгож бол болно. Ямар ч асуудалгүй. Аа нүүдлийн соёл иргэншлийн асуудал гэж яриад байгаа чинь одоо

энэ бэлчээрийн мал аж ахуйтай тойроод байгаа ард түмэн чинь яаж амьдрах юм бэ гэдэг л асуудал байгаа байхгүй юу. Тэрнийг нь бид нар эвдэхгүйээ, энд л соёлын өв нутаг байгаа, археологийн дурсгалаа авран хамгаалах ажил хийгээд, одоо талбайг нь чөлөөлөх асуудал байна. Тэр нь олон улсын ЮНЕСКО-гийн байгууллагатай манай Монгол улс эрх зүй яаж харьцахыг бид мэдэхгүй. Тогтохсүрэнгуайн хэлдэг саналтай бол би санал нэг байна судлаач хүний хувьд.

**Д.Тогтохсүрэн:** Монголчууд бол юу яадаг байхгүй юу. Хот байгуулъя гэхээр энгийн л юм ярьдаг байхгүй юу ний нуугүй хэлэхэд. Манайхан бол юу гэж ярьдаг вэ гэхлээр Хархориноос Өлзийт хүртэл 100 км байдаг энэ хөндийг л Орхоны Хөндий гэж ойлгоод байгаа байхгүй юу. Тийн тэгээд энэ хүрээнд л хот байх ёстой гэж үзээд байгаа юм. Энэ хүрээнд Эрдэнэбаатаргуай сайн мэдэх байх маш олон хотууд байсан. Том нь бол 4,5 хот бол байсан. Тэгэхээр энэ хүрээнд л өвч үзээд байгаа байхгүй юу. Тэгэхээр цаашаа Батцэнгэлрүү явчихвал өөр болоод явчих гээд байна. Тийм л учраас би бол яг энэ Өлзийт, Хархорин 2-ын хооронд л байх ёстой гэж үзэж байна. Тэгээд Өгий нуур дээрээ тавьчихаар бол ний нуугүй хэлэхэд ингээд одоо бол төлөвлөлтөө бол Өгий нуур дээр хийчихлээ. Дараа бол ингээд энэний дараа бол ийм процесс явагдана ш дэ. Хөдөө, орон нутгийнхан ялангуяа Архангайнхан эд нар сайн ойлгох хэрэгтэй. Энэний дараа бид нар энэ газрыг улсын тусгай хамгаалалтанд авна гэдэг яригдах асуудал гараад ирнэ. Хамгийн том асуудал нь тэр ш дэ. Тэгэхээр нөгөө сумын газар нутаг хөндөгдөж эхлэхээр, Өгий нуур, Хашаат, Хотонт тэ хамгийн түрүүнд ямар байр суурь гарах вэ гэдэг асуудал гараад ирнэ ш дээ. Тэгэхээр Өгий нуурын нөгөө нэрлэдэг сумынх нь Нуурыг аваад, сумын төвийг аваад бараг сумын төв нь орчихсон байна тэ. Сумын төв мөв нь ороод явах нь байна ш дээ. Тэгэхээр ингээд л бодох байхгүй юу хэдүүлээ. Тэгэхээр тэд нар эсэргүүцнэ ш дэ. Тийм учраас болвол олон талаас хэдүүлээ бодож ярья. Энэ дээр заавал нээх маргаад л байх хэрэггүй болов уу. Ер нь Дэлхийн соёлын өвийнхөн би бол олон удаа хэлж байна тэ. Баярбат даргаа хурал бүр дээр дэлхийн соёлын өвийнхөн халдуулахгүй л гээд байгаа юм. Би бол халдахгүйгээр хот байгуулж чадахгүй байна л гээд байгаа юм.

Бид нар бол эхэнд нь нэг ийм юм шийдмээр байгаамаа. Би бас 2,3- н удаагийн хурал дээр байнга 1 л юм ярьж байгаа. Эхлээд бид нар хот байгуулалтын хүрээнд авч үзэх газар, байршлынхаа асуудлыг тогтчихмоор байгаамаа. 26 гэх юмуу, 30 гэх юмуу, 50 гэх юмуу хэдэн мянган га газар гэдгээ эхлээд нэг соёлын өв, Шинжлэх ухааны академи, за энэ Хүрээлэнгүүд, Барилга хот байгуулалтын яам, өөр оролцдог газар чинь хаана байгаа билээ аймаг сумдууд ярьж байгаад энэ газар гээд тогтчихмоор байгаа юмаа. Тэгээд тэр тогтсон газраа төлөвлөлт, судалгаагаа хийлгэмэр байна. Тэгээд төлөвлөлт, судалгаа 2-оо тэн дээрээ хийгээд, тэгээд тэндээсээ хуних ажлаа хийгээд, тэгээд байршлын бүс нь энэ болох нь байна шүү гэж ярих л хэрэгтэй болоод байна гэж л би одоо ингэж л эхэлж явах л хэрэгтэй гэж л одоо анхаасаа бодоод байгаа юм. Би бол зүгээр нөгөө газар нутгийг нь мэддэг хүний хувьд юу гэж боддог вэ гэхлээр Хөшөө Цайдамаас л цайшилмаар байгаа Хөшөө Цайдамаар бараг таслаад л тэгээд цаад хэсгийг нь хот төлөвлөлтийн газар оруулчихмаар байгаа юмаа. Одоо энэ чинь Хөшөө Цайдамаас цаашаа бараг 30км байгаа юу? Одоо өнөөдрийн Хархорин ч гэсэн яг л залгаа л байж байгаа ш дээ. Танай нутаг Хөшөө Цайдамаас цааш хэдэн км явах вэ?

**1:08:48 :** 5км л байгаа бай. Худаг уултай яг Музейгээс 5км орчим л байгаа, тэгээд баруун тийшээгээ нөгөө юу

**Д.Тогтохсүрэн:** Аягүү өргөн байгаашдээ 5км орчим байгаа

**1:08:58 :** Өргөн 183мян.га орчны бүстэйгээ, орчны бүс нь 66мян.га, тэгээд нөгөө 121мян.га, 967мян.га -гаа нэмэхээр 183мян.га-г хамарч байгаа.

**Д.Тогтохсүрэн:** Хөшөө Цайдамаас цаашаагаа хэдэн га газар байгаа вэ? Тэрийг энэ зурган дээр үзэж болох уу?

**1:09:14 :** 5км орчим л байгаа.

**Д.Тогтохсүрэн:** Тэр их өргөн байгаашдээ Өгий нуур хүртэлх.

**1:09:20** : Баруун тийшлээд Хотонтынхоо Хар булагаас хойшоо Дойт Толгой гээд байдаг ш дээ. Өгөдэй хаан байсан гэж таамагладаг тэрнээсээ аваад л наашаа Хөшөө Цайдам, тэгээд урагшаагаа гараад ирдэг байхгүй юу. Тэгээд баруун тийшээгээ Бат-Өлзий тодорхой Шанхийн хуучин төв, Төвхөний хийд өөрөө тодорхой нэг хэсгээр нь янзлаад явчихсан

**Д.Тогтохсүрэн:** Энэнээс дээшээ бол хот байгуулах боломжгүй. Хархориноосоо дээшээ тэ. Ганбаатаргуай тэ энэ дээшээ бол боломжгүй. Уул, нуруу, ус гээд их хэцүү. Талбайн хувьд ч. Ерөөсөө л түүхчид археологчидгүйгээр энэ бол 100 км шүү. Ерөөсөө л Хархорин Өлзийт 2-ын хооронд 100 км бий, энэ 100 км бол ирээдүйн монголын хот шүү гэж. Тэгэхээр энэ хотын чинь 60% дэлхийн өвд орчихоод байна.

**Д.Тогтохсүрэн:** Гүй ээ харин би хэлээд байхгүй юу. Энэ хот төлөвлөлтөө хийхийн тулд дэлхийн өвийн газраас цаад талын Хөшөө Цайдамаас цааших хэсгийг төлөвлөлтөнд оруулъя гэж бодож байна. Хувь хүн талдаа эсэргүүцээд байгаа юм шиг боловч, Дэлхийн өвийн маань шаардлага ийм байна шүү гэдгийг л мэдээллэх ёстой, таниулах ёстой байна.

**Д.Тогтохсүрэн:** Өнөөдөр хэдүүлээ хуралдсаны ач холбогдол болгоод Цайдамаас цааших хэсгийг ч юмуу тодорхой хэсгийг судалгаандаа хамруулж авч үзье гээд л ярьж болж байгаа байхгүй юу. За ер нь бол энэ суурьшлын бүс байгуулах ажил маань олон нийтэд мега том ажил. Дээрээс нь Засгийн Газрын мөрийн хөтөлбөр, Монгол улсын урт хугацааны бодлого мэдээж бол угаасаа төлөвлөгдсөн ажил хийгдэхийг бол зарчмын хувьд дэмжиж байгаа юмаа. За яахав энэ судалгааны ажил дээр бол бид санал алга, өндөр онолын түвшинд мэргэжлийн хамт олон, мэргэжлийн улсууд ажиллаж байгаа учраас судалгаан дээр бол ямар нэгэн санал алга. Түрүүний яахав Тогтохсүрэн даргын яриад байгаа, Эрдэмтдийн яриад байгаа Манай улс зайлшгүй анхаарах зүйл мөн л дөө. Яалтачгүй одоо магадгүй зүгээр дэлхийн өвөөс ингээд судалгаа хийгээд гаргъя гэж байна. Тиймээ. Монголын одоо ингээд дэлхийн улсуудыг анхааралыг төвлөрүүлдэг, аялал жуулчлалын наашаа авчруулдаг гол цулбуур нь энэ өөрөө дэлхийн өвд бүртгэлтэй байгаа газар нутаг. Энэ жолоогоо бас тасдаад хаячихвий гэдэг дээр бид нар бас нилээн сайн анхаарч, олон талаас нь ярилцах нь зүйтэй байна. Дээрээс нь бас Тогтохсүрэн даргын хэлээд байгаа энэ бүс нутагт ажиллаж, амьдарч байгаа энэ малчид, хөдөлмөр эрхэлж байгаа улсуудын мэдээж хувь хүний асуудал хөндөгдөнө. Ийм учраас болгоомжтой яг одоо бид нар төлөвлөчихдөг, дараа нь газар нутгийн асуудал яригдахад нөгөө иргэд маань бас үгүй гэдэг асуудал хөндөгдөхвйдээ. Ийм учраас нилээн бас анхан шатнаас нь бас жоохон үзэл суртлын хувьд зохион байгуулж хэлэлцүүлгэ их хийж , аймгийн хэрал дээр танилцуулж, ингээд бас нилээн нарийн ажиллахгүй бол наана нь одоо бид нар яриад хийсвэр зүйл болчихвий дэ гэж санаа зовж байна. Дээр нь одоо юу гэдэг юм аймар тийм энэ дээр бол ач холбогдолтой ажиллах субъектууд биш, яг эцсийн мөчид энэ УИХ-р орно. Тэгэхээр аймгаас сонгогдсон УИХ-н гишүүдэд нилээн өндөр байр суурьтай оролцох байгаа гэж бодож байна да. Баярлалаа та бүхэнд.

**Отгонбаяр** : Тийн. 2018онд би Улаанбаатар хотод дэлхийн өв бүртгүүлж байсан. Юнеско хуралдаад бүртгэж авсан. За ингээд дэлхий бүртгэж аваад ингээд гаргаад аа гэхдээ бол манай гаргасан саналуудаас бол ерөнхийдөө бүртгэхэд 10 шалгуур байдаг юм байна лээ. 6 нь соёлынхоо, 4 нь байгалийн өвийг өвлөх ийм 10 чиглэл. Энэ дэлхий бол бүртгэгдсэн газар энэ зургаагийн нэгийг бүрдүүлэхэд ерөн бүртгээд явчихдаг. Нэг л хангаж байгаа. Манайх бол энэ соёлын 6 номинацийн 3-ыг нь хангаж одоо ингэж бүртгүүлсэн. Үүн дээр бол ерөнхий юуг нь авч үзсэн бэ гэхээр ерөнхий ойлголтоор нь хэлэхэд бол энэ бол одоо нүүдлийн соёл иргэншлийн нутаг байна аа гэж үзээд нэг дэхийг нь авчихсан. Хоёр дахь нь бол нүүдлийн болон суурин иргэншил хосолсон ийм нутаг байна гэж, гурав дахь нь бол одоо олон зуун жил хүн үүсэж одоо амьдарч байсан ул мөр соёлт давхарга байна аа гэж үүгээр үзчихээд бүртгэж авсан юм байна лээ. Тэгээд бүртгэж аваад энэ болвол Монгол улсын төдийгүй энэ бол дэлхийд хүн төрөлхтний хосгүй үнэт хадгалж хамгаалвал зохино гэсэн ийм газар нутаг гэдэг тэр гэрчилгээгээр бол ингэж бүртгэж авсан.

**Д.Тогтохсүрэн:** За ойлгосон бүртгэсэн тухайд лекцээр яахав тэр нөгөө хамгийн гол нь тэр Хөшөөцайдамаас цааш хэдэн га газар байгаа гэдгийг харчих боломж бий юу?

**Г.Нарангэрэл** : Тэрийг 24 гэж байсан, 30 хэдээсээ хасаад 24 мянга хэдэн зуу. Нутагруугаа ороод тодорхойлсон нь бол 8,300 байгаа юм.

**Ц.Баярбат** : Тийм, нийтдээ 34,770 гарсан юм тэндээс 8,300 нь илүү гарчихаад байгаа. Цаашаа үлдэж байгаа нь 26,000 гэж яриад байгаа юм. Наашаа ороод ирэх юм бол 34,770-ыг хасаад. Ер нь баримжаа авахын тулд бол хүмүүст хэлэхэд нийслэлийн орчмын нутаг дэвсгэрт бол 470 мянган га, бид нар 2020 онд төлөвлөлт хийхэд бол барилгажилтынхаа төслийг 46-47 мянган га, одоо бол нийслэлээс 47 гараад явчихсан байж байна. Сүүлийн дүгнэлтээр бол тэгээд тийм байж байж

**Д.Тогтохсүрэн**: 1,5 чинь нийслэлийнх биш, нийслэлийнх болохоос Улаанбаатарынх биш, Улаанбаатартаа болвол дагуул харьяа хотуудаа хасаад ирэхээр нэг сая, сая газар л авна. Хүмүүс буруу ойлгоод байгаа юм. Нийслэл гэдэг юм нөгөө 400 хэдэн мянган яг Улаанбаатар хотын хэсэг гэвэл тэр дундаа бүр Улаанбаатар хот нь өөр Улаанбаатараасаа гадна тэр чинь дахиад Сонгино монгино баахан тосгонуудыг бол тусдаа авч үзнэ. Яг Улаанбаатар нь хэд вэ?

**Д.Тогтохсүрэн**: Улаанбаатар нь гэвэл одоо нэг сая орчим л хүн байгаа.

**Г.Нарангэрэл**: Сая 300, Төвийн 6 дүүргээ оруулаагүй юм байна тэ

**Д.Тогтохсүрэн**: Төвийн 6 дүүргийн хүн бүгдээрээ орохгүй. Га газрыг нь яриад байна

**Г.Нарангэрэл** : Га юу одоо яг барилгажилт орохгүй. Тэр дотроо, би нэг санал хэлье л дээ. Яахав хот гэхээрээхотын эдэлбэр газар гэж юм байгаа. Тэр дотроо барилгачин хэсэг, түүгээрээ бол нэг хэсэг барилгажуулах хэсэг 2 хуваачих нөгөөдөх нь хадгалж хамгаалах хэсэг. Тэгэхэд биднийхээр бол яг барилгач хэсгээ 40 хэдэн мянган га 1 сая хүний юмыг хэлээд байгаа шүү дээ. Одоо бидний 40 оноор бол саяд 100 хүн байна аа. Ингэхэд тэнд хэд нь хэрэгтэй байна гэхээр 40 хэдэн мянган га байна. Тэгээд миний бодлоор ингээд харахад ингээд жижигхэн жижигхэн юмнууд аваад байхаар энэ бол ирээдүйд том хот болох ямар ч найдвар байхгүй учраас ирээдүйд бидний үе одоо бид энийг бол 20 гаран жил ярьж байна шинэ нийслэл байгуулна гээд тэгэхэд ирээдүйгээ харах ёстой зөвхөн бид нар 20,30 хүний асуудал биш энд яваандаа шинэ нийслэл минь дор хаяж сая хүн юм уу, бүр бага байхад 500,600 мянган хүнтэй хот багтах нутаг дэвсгэрийг бол бид нар олох хэрэгтэй. Ингээд ахиад яаж байна гэхээр энэ хүний хэлдэг маш зөв энэ дэлхийн соёлын өвд халдаж болохгүй. Энэ чинь бидний юм биш дэлхийд яачихсан. Бид нар дэлхийн өмнө гэмт хэрэгтэн болох юм уу? Тэр өвийг сүйтгэх, тэгэхээр энд ерөөсөө орж болохгүй. Археологи гэдэг тэрний нэг л хэсэг энд дэлхийн түүх ярихаар манай чулуун зэвсгийн үеэс ирсэн энэ хичнээн 10 хэдэн үе байна. Чулуун зэвсгийн үеэс энэ хичнээн 10 хэдэн үе байна Чулуун зэвсгийн үеийн бууц нь хүртэл байж байна. Бүх Монгол улс хүчирхэг байхдаа энд дандаа нийслэлээ байгуулж байсан. Тэгэхээр энэнд их ойртож болохгүй би бол аль болохоор хол. Юутай яахав гэвэл дэлхийн туслахууд бид нараас судлаад дахиад шинэ олдворууд гол дэд бүтцээрээ, улсынхаа гол зам одоо тэгэхээр мянганы зам хойгуур явж байгаа биз дээ. Би энэ Тогтох гуайн гаргасан, Чинбаа багшийн гаргасан санааг аягүй дэмжээд байгаа юм. Хойгуур шинэ нийслэл гэдэг концептийг бол хойд талд хийж байсан. Тэрний өмнө манай Дажав багш 90 хэдэн онд энэ болохгүй юм аа гээд тоглохын талд санал гаргаж байсан. Одоо миний бодлоор бол эцсийг нь би өөрөө энэ Ховдод одоо 40 хэдэн жил ажиллаж байгаа болохоороо юу гэж байна вэ гэвэл эхний ээлжинд зүгээр талбай нэг 500-аас дээш, 1,000 хүнтэй хүн байх талбай бол 2 гэж байна. Тоглохын талд байна. Тэр та хоёрын сонгодог чинь арай зүүн тийшээ. Тэгэхээр энэ бол ирээдүй байхгүй ээ зүгээр нэг жижиг 20,30 мянган хүнтэй юм хийж болно. Одооминий яриад байгаа бол Өгий нуураасаа хойшоо гараад энэ хойд талын одоо нөгөө мянганы замгол зам дээрээ тэр байх ёстой. Яагаад гэвэл энд тэр олон хүн, машин тэрэг ирнэ. Яагаад гэвэл улсынхаа гол тэнхлэг дээр байх ёстой учир энд юм уу, тэнд байвал мянганы замтай их ойрхон. Энэ дээр тийм 40 хэдхэн км юу юм бэ. Тийм учраас энэ сарын эцэн энэ чинь юу гэвэл зөвхөн юу биш энэ чинь байгалийн унаган байгалиа авч үлдэх, илүү энд байгаа хүмүүс мал сүргээ хариулахдаа хуучныхаа юмаар ингэж сайхан амьдрах нөхцөл байх болохоос энд хот байгуулах тухай асуудал байж болохгүй. Ийшээ бүр ингэж хасах, шахаж байрлах тэр бол ерөнхийдөө тэр яахав бид нар судалж байгаа. Харахад энд бол 40 гэхэд одоо 20,30 мянган хүнтэй л хот барина шүү дээ.

**Ц.Баярбат:** Гэхдээ Өвийг хадгалаад байх ёстой юм уу менежмент хийх ёстой юм уу гэдгээ бас бодох ёстой.

**Г.Нарангэрэл :** Үгүй ээ, тэр чинь менежмент гэж юуг хэлээд байгаа юм бэ? Тэрэн дээрээ байшин барина шинэ юм барина гэсэн утга биш байхгүй юу. Тэрэн дээр нь байгаа ард иргэдийнхээ амьдралыг сайшааж, уламжлалт юмыг нь сэргээнэ гэдэг утга байгаа байхгүй юу.

**Ц.Баярбат:** Тийм тийм

**Г.Нарангэрэл:** Тэрнээс биш шинэ хот барина гэсэн утга байхгүй. Одоо тэрийг очиж үзвэл аль болох уудам нутгийг ирээдүйдээ болвол талбайгаа зөв сонгох хангалттай цаашаа хөгжих боломжийг хангасан юмыг л сонго. Одооны энэ байршлаар болвол яагаад гэвэл 2006-7 онд түрүүнд байсан “Хархорин, Эрдэнэзуу орчмыг аялал жуулчлалын төв болгох” гэдэг судалгааг хийж явж байхад хэлж байсан. Энэ доор бол хичнээн юм байна. Бид нар зүгээр тэр хүнд судалгаа хийгээд нэг семинар болж байхад энэ амнаас Уйгурын анх удаа хананы гэрээслэлтэй юм олж байсан. Зүгээр байж байсан чинь нэг хүн хашаандаа жорлон ухсан чинь галбинга гээд ийм юм оллоо гээд зүгээр хашаанаасаа олж байсан. Ингээд энэ дор хамаагүй хөндөж болохгүй асуудал байна. Дээр нь хамаагүй юм барьж болохгүй. Социализмын үед тэр сайхан газруудыг тариалаад явж байхад нь тэр хуяг, дуулга гарж ирдэг байсан. Тэгэхээр энийг бол нандигнан хайрлах газар дээр нь юм барьж болохгүй аль болох 40,50 км-ийн цаана бариач дээ. Хангалттай газар миний яг мэргэжлийн хүний хувьд би энийг хэлж байна.

**Тогтох :** Тэр дэлхийн өвийн газраас хойш 4,5 км-ээр жаахан намагтай тийм газар байгаа. Тэгээд сайхан газар бий. Өгий нуурын хойд энгэр, за даа Өгий нуур сумаас нааш 2 ойрхон холбогддог хойд, урд гээд барилга барихад боломжгүй гэсэн газар миний хувьд байхгүй юм. Барилгыг чинь одоо ер нь далай дээр гүүр тавьж байна шүү дээ. Жаахан намагтай гээд болохгүй юм байхгүй яахав зүгээр суурийн зардал жаахан нэмэгддэг юм. Техниз хөгжөөд асуудал байхгүй. Тэгээд тэр 26 хэдэн мянган га тэр чинь хангалттай газар уу, Тоглохын тал, Тамирын хөндий рүү яваад байх ч юм байхгүй. Барилга барина хот байгуулна гэдэг чинь олон барилга барина гэж би ойлгодог. Яахав тэрнийг эмх цэгцтэй барих л юм. Энэ 26 мянган гад энд нь болно энд нь болохгүй гэсэн юм байхгүй. Тийм учраас бол одоо хот байгуулах бол нэг хэсэг тэгээд нуурын нэг хэсэгт хот чинь бас заавал үргэлжилсэн юм байх албагүй шүү дээ. Ийм учраас энд бол хориод байх юм байхгүй ээ. Хот байгуулах бүрэн боломжтой гэж би үзэж байна. За тэр хэн гуайн тэр нүүдлийн соёлын гол учраас тэрийгээ яаж хамгаалах юм гэдэг асуудал байна л даа. Энэ Хархорин хөндий бол бүхэлдээ энэ зурган зурсан байгаа бүгд чинь нүүдлийн соёлын голомт мөн дэлхийн өвд авсан аваагүй гээд бүгдийг нандигнан хадгалдаг, тийм ч учраас энэ олон дурсгалт газрууд олон нийслэлүүд байж байгаа юм. Тэгээд бид одоо гол нь тэгчихээд ер нь ирээдүйн нийслэл Улаанбаатарт цаашаа нийслэл байгаад байх боломж их бага байгаа шүү дээ. Тэрнийг ямар нэгэн хэмжээгээр одоо нийслэлээ одоо бас зөөх шилжүүлэх шаардлагаар хэдүүлээ бас хөрөнгө авч байгаа. Энийг чинь 96 онд УИХ-д өргөн баригдсан Монгол улсын хөгжлийн үндсэн үзэл баримтлал дотор чинь энийг чинь заагаад тэгээд одоо эхний тогтоол нь 2001 онд 1-р тогтоол гараад, дараа нь одоо ардчилсан хувьчлалын 54-р тогтоол гараад дараагаар нь 2003 оны 1-р тогтоолоор Хархорины байгууллага хөндлөн бусаар тэмдэглэлийн огтолцолд хамгийн ойрхон төв нь бүсийн төвд байна гэсэн концепт явж байгаа шүү дээ. Энэ чинь бол бидний дээд үеийн хийсэн хөгжлийн концепт. Тэрүүгээр бид одоо явж байна. Яахав 2003,4 онд тэр үед Их Хуралд өргөн барьж танилцуулж байсан хүн нь сайн хэрэг. 2006 онд бол улсын барилгын зургийн төв институтын захирал танилцуулж байсан. Ер нь бол энэ улсын барилгын зургийн төв институт төлөвлөлтийн сектор барилгын – сектор гээд 10 хэд 10 хэдэн хүнтэй бүхэл бүтэн яваад улсын төлөвлөгөөний оффисын даалгавраар он жил дарааллан хийж байсан ийм эцсээс нэгтгэж өгөөд тэр том төсөл шийдвэр 96 онд тэрний 3 парлапт дамжуулан 6 тогтоол гаргасны 3 дахь тогтоол нь тэр 2 хүнийх байхгүй юу. Одоо энийг бас судалж байгаа улсууд нь түүхээ үзээд тэрэнд холбогдох материалуудыг судалж үзэхэд саяны миний хэлэн гараад ирнэ архивт байж байгаа. Ийм л учиртай юм. Тэгээд тэр нүүдлийн соёлын иргэншлээ хадгалж үлдэнэ гэдгээ хотын хөдөлгөөндөө яаж уялдуулахаар, тэгэхээр одоо хотод байх нь хотын айлууд, малчид малаа хариулаад явдаг байх нь тэрний одоо бололцоо

нөхцлийг хангасан хотод ч байна, нүүдлийн соёл нь ч байна гэж би хэлнэ. Байхдаа зэрэг 26 гэдэг чинь бол

**Ц.Баярбат** : Ерөнхийдөө бол барилгажих боломжтой талбай гэж л гаргасан. Яг нөгөө хотжилтын бүсээрээ гэвэл энэ өөрөө 40,50 мянган га-тай. Хотжилтыг дэмжих бүс нь өөр болно. Бидний барилга барих боломжтой гэдэг нь 26 мянга га. Харин эдэлбэр газрын хэмжээ гэвэл нөгөө барилгачдыг дэмжих, дэмжихгүй бүс гэвэл ахиад өшөө өөр төлөвлөлттэй байгаа. Энэ нь одоо судалгаагаар боломжтой гэж гарсан л юм

**1:29:35** : Энэ Хашаат суманд одоо яахав сумын дарга нь холбогдоод байна л даа. Уул уурхайн 8 лиценз өгөгдөх гээд яваад байгаа юм уу? Ер нь ингээд хэлэлцээрт тийм юм бас гарчихсан яваад байгаа юм байна лээ шүү. Энийг бас ажлын хэсэгтээ анхааралдаа аваад энэ дээр 8 байршил газар гэсэн. Хөшөөд сайт дээр нь залгасан гээд байх шиг байгаа юм. Тэрийг бас анхаарч та бүхэн ямар шийдвэр энэ оны 1 сарын шийдвэр ашиглаж болох төрөл газрын төрөл гээд нэг даргын гарын үсэг байсан. Энэ уул уурхайн 8 нэршил байгаа тэр нь энэ судалгааны юун дээр чинь давхцаж байна уу? Хашаат гээд суманд ороод ирж байгаа юм.

**Ц.Баярбат** : Сэжун хаана байдаг юм. Сөүлээс хойшоо Солонгосын төв хэсэгт. Сэжун төлөвлөөд явж байгаа. Ирээдүйд гэдгээрээ. Одоогоор 300 гаруй мянган хүн амтай. Тэдний тооцоогоор 500 гаруй хүн амтай болно гэж үзэж байгаа. 17 жил болж байгаа. Тэр бол нийслэл болон нийслэлийн засаг захиргааны төв хот гэдгээр, дотроо үйлдвэрлэл агуулаагүй, соёл, засаг захиргаа худалдаа үйлчилгээ, Их дээд сургууль, инноваци технологийн судалгааны хүрээлэнгүүд байна. Тэднээс бид туршлага судлая гээд одоо нарийвчилсан хамтын ажиллагааруугаа орж байна. Тэд одоо Индонез Жакартагаа 1000 гаруй км хол нүүлгэж байгаа. Их хол юм билээ. Тэрэн дээр бид бас судалгааны ажилд орчихсон явж байна. Дэлхий дээр нийслэл хотоо нүүлгэх шийдвэр гаргаж байсан судалгаа 20 гаруй байна. Үүнээс хамгийн амжилттай явсан 5-6 байна. Жишээ нь Солонгосын Сэ жун гэх мэт. Тийм юман дээр хараад таны хэлсэн алсын хараа гэдгийг тодорхойлох хэрэгтэй юм.

**Тогтох:** Монголчууд бидний хувьд ялгарах юм бол нүүдлийн соёл иргэншил суурин соёл иргэншилийг хосломол хэлбэрийг яаж хот байгуулалтад бий болгох вэ гэдэг асуудал. Тэгэхээр бид үйлдвэрлэлээ дагуулах уу, аль эсвэл нүүдлийн засаг захиргаа соёлоо голлох уу гэдэг чухал. Солонгос яагаад нүүлгэх болсон вэ гэдгийг харахад манай жишээтэй адил Сөүлд бүх юм нь төвлөрчихөөд 10 гаруй сая хүнтэй, бид дийлэхгүй болсоноос нутаг дэвсгэрийн тэнцвэрт байдал гэдгээрээ бодлого нь гарсан юм билээ. Манайх баруун тал нь нийслэлээс Баян-Өлгий 1500 км, зүүн тал Чойбалсан 600 орчим км байна ш дээ. Төв цэгээ 300 орчим км ээр нутгийн төв рүү оруул гэсэн даалгаварыг 1996 оны баримтад тусгасан. Тэрийг өнөөдөр хэрэгжүүлэх гэж яваа хүмүүс. Эх орны даалгавар шүү.

**Д.Тогтохсүрэн:** Яваандаа 26000 дээрээ судалгаа төлөвлөлтөө хийе гэдэг дээр тогтож байна. Эхний судалгаа. Яваандаа танай Өгий нуур сум л нийслэлийн сум болох юм байна.

**Отгонжаргал / Архангай аймгийн Газрын харилцаа барилга хот байгууллалтын газрын дарга / :** Заа та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Миний хувьд Архангай аймгийн Газрын харилцаа барилга хот байгууллалтын газрын дарга Отгонжаргал гэж хүн байна. Тэгээд бас их сонирхолтой байна. Орхоны Хөндийд шинэ суурьшлын бүсэд хот байгуулах гээд ерөнхийд нь сонсож байсан. Анхны уулзалтанд бас аймгийнхаа ажлын хүмүүстэй оролцож байгаадаа баяртай байна. Архангай аймаг Монголдоо Архангай аймаг нүүдлийн соёл иргэншлийн олон улсын төв болгон хөгжүүлэх, аялал жуучлалын төлөвлөгөө боловсруулаад НҮБ-тай хамтрахаар ТЭЗҮ зураг төслийн тендер зарлагдаад аймгийн мөнгөөр бүтсэн. Гэхдээ энэ газар нутагт түүхийг судлаад байхад нилээн олон эрдэмтэн доктор судлаачид байна. Тэдний хийсэн судалгаагаар ялангуяа Хүннү, Сянби, Түрүг, Жужан, Уйгар их эзэнт гүрний улс байсан асарих соёл голомт юм байна лээ агуу их юм байна лээ. Гэхдээ энэ нутагт саяын ярьсан засаг захиргаа соёлтойгоо хамтарсан юм байх юм бол үгүйсгэхгүй юм байна. Сайн судалж хийх хэрэгтэй. Дээр нь бид хэд манай аймгаас бол Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга ирсэн байна. Миний хувьд дээр нь ерөнхий архитехтор бид хэд бол ерөнхийдөө Архангайг

төлөвлөж амжихгүй юм байна. Манай газар нутагруу их орж ирэх юм байна. Гэхдээ хүмүүсдээ мэргэжлийн баг судалж үзээд байршлуудаа тогтоогоод аймаг, орон нутгийн хүмүүстэй уулзалт хийгээд ард иргэдэд зөв ойлгуулах юм бол болохгүй юм алга. Энэ бол асар их энерги байгаа гэж боддог. Бидний өвөг дээдэс энэ нутагт байсан. Бие биенийгээ эзлээд байсан юм байна лээ түүх үзэхээр бас их сонирхолтой юм байналээ. Энэ нутагтаа маш оновчтой төлөвлөлт хийгээсэй гэж үзэж байна. Тогтохсүрэн гишүүний санаачилж байгаа энэ ажил бас энэ нутагт байх нь зөв байх гэж бодож байна. Ер нь сайн ярих юм бол дийлэнх нь Архангайн нутагт ороод ирэх юм байна. Маш тохиромжтой бүс нутаг болно. Нуурыг тойроод өөрөө жоохон хамгаалалтын бүс татаад явах юм бол тийм ч буруу биш юм байна. Их гоё харагдана. Хот өөрөө их гоё харагдана. Ард нь бас босоо хөндлөн замууд явж байна. Бид нарын хувьд цаашдаа оролцоод зөвлөөд явъя. Бас энэ эрдэмтэдийн хэлсэн үгс бас үнэтэй шүү. Та нарт баярлалаа үнэхээрийн үнэтэй. Миний хувьд бол хажуугаар нь судлаад байгаа. Энэ бол сонирхолтой. Бид нар үнэхээрийн баяртай байна. Баярлалаа.

**Иргэн :** Юу гэхлээр яахав. Монгол Улс яг хүмүүс бас зарим мэргэжлийн хүмүүэ тэгээд байгаа амархан 1 сая хүнтэй гээд. За одоо байгаа монголын хүн ам яг хэд вэ гээд. 800 мянга нь мал аж ахуй давамгайлсан 309 сум байгаа энэ тоо хэзээ ч буурахгүй мал аж ахуйгаа дагаад дараагийх нь 1,1 сая хүн аймгийн төвүүдэд байгаа аймгийн төвүүд болон Зүүнхараа, Замын-Үүд, Хархорин гээд, дараагийн 1,5 сая нь Улаанбаатарт байна. Одоо 1,5 сая маань шууд 1 сая нь Монгол улсын хүн амын өсөлт харьцангуй ирэх 20 жилд бас төлөвлөлтөөр ингээд явна тэ. Шууд ирлээ гэж бодоход 500 нь үлдлээ гэж бодоход одоо тэнд 1,5 сая хүний тодорхой хэмжээний хот байгуулалт, инжнерийн дэд бүтэц хангагдаад явж байна. Монгол улс өөрөө бодит боломж даац маань хязгаартай байна. Аа тэгээд дээрээс нь одоо байгаа энэ Хархорин хот маань ирэх 20 жилдээ яаж орон нутгийн иргэд нь ажлын байртай болоод, аялал жуулчлалын хувьд яаж хөгжөөд бусад байдаг сумын төвүүдээс яаж ялгагдаж хөгжих вэ гэдгийг бас бид давхар авч үзэх ёстой. Эрдэнбүрэнгийн газрыг чөлөөлөхийн тулд 100 айлыг нийт 10 хэдэн тэрбум төгрөгөөр газрыг нь чөлөөлж байна тэ. Тэгвэл магадгүй энэ газар тариалангийн энэ зарим бүс нь Хархорин орчимын магадгүй энэ Монгол улсын эрх ашгийн үүднээс газарт ороод зохион байгуулалтанд орлоо гэхэд бас давхар бас газрын нөөц ашиглах боломж байна уу? үгүй юу? Одоогийн байгаа Хархорины суурьшил маань дундаж аймгийн төвүүдээс 5 дахин сийрэг суурьшилтай байгаа. Ямар нэгэн тусгай хамгаалалтанд ороогүй хэрнээ тэ. Тэгэхээр бид нар ирэх 20 жил гэдэг маань Хот байгуулалтын хувьд Хархорин маань ямар өнгө төрхтэй, энэ 15,000 хүн маань ямар ажлын байртай, заа тэгээд гадаад харьцангуй гадаадын аялал жуулчид их ирдгээрээ, гадаадын жуулчид Хархоринд 1,2 хоногоор л ирж байгаа тэр жуулчид маань энэ Орхоны Хөндий орчимын 5,6 байршил руу нэг дор тэр болгон яваад байх, цаг хугацаа боломж нь ч тийм. Аль болох яг ирж байгаа жуулчдад бас боломжтой цаг хугацаа, менежмент нь байгаад одоогийн энэ Хархорин маань энэ 15,000 хүний төвлөрөл гэдэг чинь өөрөө энэ өнгөрсөн 100 гаруй жилд бий болсон эдийн засаг хөгжлийн нийгэм, эдийн засгийн таталцлын том ололт юм. Энийг давхар хож хож загвараар одоо бидэнд алдаа байна 3 удаа энэ Орхоны Хөндийд том баримт бичгүүд гаргасан хэрэгжээгүй цаас болсон. Тэгэхлээр бид нар аль болох бодитой бас нэг хэд хэдэн хувилбараар юмнуудаа авч үзээд тэ, магадгүй одоогийн энэ газар ирээд бусад бүс дээрээ Дэлхийн хувьруу орохооргүйгээр 40-50 мянган хүн байхаар нөөц бололцоо, даац байна уу үгүй юу гэдгийг гаргаж ирээд давхар давхар одоогийн Хархорингоо яаж өөд нь татах вэ? Гэтэл одоо бусад байдаг л сумын төвүүд шиг инженерийн дэлгэцийн хангамж, ажлийн байрны асуудлууд, бусад сумын төвүүдээс ялгагдахааргүй байгаа тэгэхлээр яах вэ?

**Д.Тогтохсүрэн:** яахав одоогийн Хархорин аягүү хэцүү, түрүүн тэр хэн билээ Нарангэрэлгуай түрүүн хэлсэн одоогийн Хархорин бол үнэндээ хэлэхэд ямар ч хотжилт хийх боложгүй. Энэ чинь нөгөө Ганбаатаргуай хэлсэн дэрхийн соёлын өв соёлыг өвөөс хаагдсан болохоос биш жинхэнэ археологи энэний дор байгаа. Тийм учраас энд хот байгуулалт бол одоо энэ Хархоринд бол хэцүү. За яахав 30,40 мянган хүнтэй дээд тал нь 50 мянган хүнтэй аялал жуулчлал, шашин, ер нь яваандаа энийг Эрдэнэзуу шашиных нь төв болгомоор байна гэж

ярьдаг. Улаанбаатараас шашин гарахгүй бол болохоо байлаа гэж. Тэгэхээр энэ шашин, соёл, аялал жуулчлал хөгжсөн жижиг хот л байна. Тэгэхээр аялал жуулчлал түүхээ хадгалсан ийм л хот байна. Үүнийг хамаагүй том болгож, хөгжүүлж болохгүй гээд байгаа юм. Тэгэхээр бид дараагийн том хотын тухай л яриад байгаа юм. Одоогийн Хархоринд бол аягүй хэцүү, та бол сайн мэдэж байгаа археологичид хамгийн сүүлд гаргасан дүгнэлт нь Өгөөдэй хааны ордон чинь Эрдэнэзуугийн доор байна гээд байгаа шүү дээ. Хамгийн сүүлд Цэвээндорж гуай, Баяр гуай нар чинь энийг доор гэж харсан. Тэгэхээр л аягүй хэцүү болчихож байгаа юм. Тэгээд зүгээр хэдүүлээ Лодойгийн 26 дээр гэж тогтоод газар дундын байршлаа очиж үзээд, яваандаа бол тэлэх юм нь бол Өгий нуур, Өгий нуураас цаашаа л түрүүний таны хэлдгээр засмал руугаа мянганы зам руугаа явна бүр болохгүй бол цаашаа Гурванбулаг руугаа чиглээд л явна.

**Тогтох** : Тэгээд ус Монгол орны нутгийн төвд байгаа гол, устай газар Хархорин л байгаа юм.

**Түвшинтөр/Өвөрхангай аймгийн ерөнхий архитектор/** : Өвөрхангай аймгийн ерөнхий архитектур Түвшинтөр, за энэ тусгай хамгаалалт, одоо хот байгуулалтын хууль бол зөрчилдөх нь бол тодорхой тийм учраас одоо энэ бидний яриад байгаа манай хот байгуулалтынхан ярьлаа. Ер нь бол шинжлэх ухаан талаасаа бүх судалгаа шинжилгээг хийгээд, хот байгуулалт талаасаа бүх судалгаа шинжилгээгээ хийгээд одоохондоо бол тусгай хамгаалалтын гаднах гэдэг тал руугаа явахгүй болвол тэрэн дээрээ уялдуулж хот байгуулалтын хууль, хот байгуулалтын хууль бол хөгжлийн хууль, тусгай хамгаалалт одоо энэ Өгийн хууль бол маш чанга хууль дэлхийн хэмжээнийх. Тийм учраас энэ хот том хуультай хот байгуулалтын хууль бол яг үнэндээ болвол төлөвлөлтийн хувьд зөрчилдөнө. Тийм учраас нөгөө шинжлэх ухаан, хот байгуулалтын чиглэлээр байх ёстой, хийгдэх ёстой бүх судалгааг нь хийгээд тодорхой хэмжээний газрыг чөлөөлөх боломж байдаг бол тэр тал руу нь явбал талбай гарж ирэх боломж байгаа. Миний хувийн санал бол хот байгуулалт талаасаа явж байгаа л даа. Одоо жишээ нь Хархорины одоогийн бүтээн байгуулалтыг хийх гэж бас хамгаалалтын нэг газартай бол хэцүү шүү дээ. Дэлхийн өвийг хамгаалаад байж байна. Бид нар хот байгуулалт хийх гээд энд байгаа иргэдийн аюулгүй байдлыг бодож, энэ хотын цаашдынх нь хөгжлийг бодож хот төлөвлөлтийг хийдэг. Гэтэл яалт ч үгүй маш том хамгаалалтын маш том дэлхийн хэмжээний хууль журамтай мөргөлдчихдөг. Тэгэхээр Хархорин хөгжиж байна. Хөгжлийг цааш нь явуулах гэхээр маш том хуультай зөрчилдөх зөрчлийн хууль. Тийм учраас яг л гишүүний түрүүний хэлснээр 2 талаасаа ярилцаад хоёр талынхаа хот байгуулалтынхаа чиглэлээр бүх байх л судалгааг нь хийгээд нэг гаргалгааг гаргахгүй бол энэ тусгай хамгаалалтын газар дээр хот байгуулалтын үйл ажиллагаа уялдуулж явна гэвэл урагшлахгүй байх гэж бодож байна. Тэгэхээр түрүүний гишүүний хэлдгээр бол манай энэ миний хувийн зүгээс хот байгуулалтыг явуулья гэвэл төрийн тусгай хамгаалалтын газраас тодорхой хэмжээний газар гаргах шаардлагатай гэсэн байр суурьтай байна. Тусгай хамгаалалтын газар дээр хот байгуулалтын үйл ажиллагааг уялдуулж явуулна гэвэл урагшлахгүй байх гэж үзэж байна. Миний хувийн бодлоор хот байгуулалт хийнэ гэвэл тусгай хамгаалалтын газраас тодорхой хэмжээгээр гаргах нь зөв л гэж үзэж байна.

**Л.Дэлгэрдалай:/Архангай аймгийн ерөнхий архитектор/** Монгол Улсын шинэ хот төлөвлөж байгаад баяртай байна. Энэ 26 мянгад Өгийнуур сум нь бас аялал зуучлалын бүс болох яг Өгийнуур нь ороод байна. Энийг төлөвлөөд явахаар тусгай хэрэгцээнд авна гээд байна. Тэгэхээр манай аймгаас 1 сум хасагдах гээд байна.

**Д.Тогтохсүрэн** : Явж явж Өгийнуур сум хот болох нь. Нуураа тойроод маш том аялал жуулчлал хөгжөөд маш гоё болох гээд байна.

**Л.Дэлгэрдалай:** Энэ бас аймгийн удирдлага, Их хурлын гишүүд бас бодолцох хэрэгтэй л байх. Манай Архангай аймгийн хувьд хот байгуулах талыг дэмжиж байна. Бид төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй хүмүүс. Хотыг дэмжих талаас нь зохион байгуулалтанд орж ажиллана. Миний сайн мэдэх зүйл бол Тогтохсүрэн гишүүн бидний жаргал зовлон ард иргэдийн сэтгэхүйг сайн мэдэх учраас энэ төлөвлөлт маш мэргэн төлөвлөлт болох байх гэдэгт итгэж бодож байна.



**Д.Тогтохсүрэн:** Иргэдийн зүгээс ганцхан субъект л эсэргүүцнэ. Малчид. Бэлчээр гэж. Тэрнээс бусад нь бол үгүй. Амьдрал бусад зүйлд шал өөр нөлөөлнө. Малчид л жаахан эсэргүүцээд байдаг юм. 26 мянган га-д байгаа малчдын эргэн тойрны бүсийн асуудал.

**Отгон:** /Барилгын хөгжлийн төвийн газарзүйч, бүс нутаг судлаач/: 1 санал хэлье. Энэ ажил дээр манай барилгын хөгжлийн төв захиалагчийн үүргээр ажиллах байх. Хүмүүсийн хэлсэн саналаас өөр санал хэлье. Өгий нуур маань Олон улсын ус намгархаг газрын усны шувуудын хамгаалах Рамсарын конвенцед орсон. Увс нуур, Тэрхийн цагаан нуур, Орог нуур гэх мэт 5,6 нуурыг оруулсан байгаа. Тэр бол 26,000 га газарт Өгий нуураа тойроод байгаа учир энэ олон улсын конвенца анхаараарай. судалгаа хийж буй хүмүүс анхаарч ажиллаарай. Сум байгуулах барилгажилтанд бас усны шувуу нөлөөлнө шүү.

**Шийдвэрлэсэн нь:**

1. Архангай аймгийн Өгийнуур сумын нутагт шинэ хот байгуулахыг дэмжих,
2. Хотын хүн амыг хязгаарлах талдээр анхаарч төлөвлөх,
3. Археологийн дусгалт зүйлс, газар нутгийг хамгаалах арга хэмжээ тусгах.

Хурал 14:00 цагт өндөрлөв.

Хурлын тэмлэглэл бичсэн:

Хурлын тэмлэглэлтэй танилцсан: